БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ, ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот
2018 оны 3 дугаар сарын 20

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

БХБЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Д.БАТЗОРИГ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ




БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 4.1.21.-Т “БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ГЭЖ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 15.14-Т ЗААСАН БАРИЛГЫН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХИЙГ; / *15.14.6.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;* **/**

33.1.15.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих **журам батлах;**

34.1.14.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд **тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах;**



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН “ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР ТУШААЛ, ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН УЛСЫН НЭГДСЭН САНГИЙН 3841 ДУГААРТ БҮРТГЭГДСЭН.



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 3841 дугаарт бүртгэв.

БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 19 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, үсгралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журам”- ыг хавсралтаар батална.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2013 оны 89 дүгээр тушаал, 2017 оны 204 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Х.БАДЕЛХАН

03 00054



Барилга, хот байгуулалтын сайдын
2018 оны 01 дугаар сарын 19-ний өдрийн
11 дугаар тушаалын хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн этгээдэд мөн хуулийн 4.1.21-д заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, бүртгэх, хугацаа сунгах, тэдгэлзүүлэх, сэргээх, нөхөн олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан тавих шаардлагыг хангасан хуулийн этгээдэд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоно.

1.3.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх **/цаашид “барилгын материал үйлдвэрлэх” гэх/, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, үсгралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 33.1.15-д заасны дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.**

1.4.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 20.7, мөн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

1.5.Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, нөхөн олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

1.6.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль болон энэ журмаар зохицуулна.

1.7.Барилга байгууламжид паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ЗТ-4.1 ажлын төрөлтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ. Тухайн ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж эзэмшдэг байгууллагатай гэрээгээр хамтран ажиллаж болно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Барилгын тухай

ЖУРМЫН ТУХАЙ.



1	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ
3	ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
4	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
5	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА
6	ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ, НӨХӨН ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
7	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН БАРИМТ БИЧГИЙГ БАЯЖУУЛАХ ХАДГАЛАХ
8	БУСАД

ЖУРАМД ТУССАН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД



1.7. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ПАСПОРТЖУУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭНЭ ЖУРМЫН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТАД ЗААСАН ӨНДӨР ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ **ЗТ-4.1** АЖЛЫН ТӨРӨЛТЭЙ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГҮЙЦЭТГЭНЭ. ТУХАЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДЛАГАТАЙ, БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЭЗЭМШДЭГ БАЙГУУЛЛАГАТАЙ ГЭРЭЭГЭЭР ХАМТРАН АЖИЛЛАЖ БОЛНО.

3.1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨРГӨДЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА ХҮЛЭЭН АВСНААС ХОЙШ АЖЛЫН **10** ӨДРИЙН ДОТОР МЭДЭЭЛЛИЙН САНТАЙ ТУЛГАЛТ ХИЙЖ, **АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНД ОРУУЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛНЭ.**

3.2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗСАН БОЛ ЭНЭ ТУХАЙ ҮНДЭСЛЭЛИЙГ ТОДОРХОЙ ЗААЖ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА **АЛБАН БИЧГЭЭР ХАРИУ МЭДЭГДЭНЭ.**

3.3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙГ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 12.3-Т ЗААСНЫ ДАГУУ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААР ШАЛГУУЛЖ БОЛНО. ЭНЭ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХИЙГДЭЖ БУЙ ТОХИОЛДОЛД ӨРГӨДЛИЙГ **14 ХОНОГИЙН ХУГАЦААГААР СУНГАЖ БОЛНО**.

ЖУРАМД ТУССАН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД



4.4. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТЭДГЭЭРТ ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ **ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРЭЭР БАЙГУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ** ЗОХИОН БАЙГУУЛНА. /ЦААШИД “АЖЛЫН ХЭСЭГ” ГЭХ/

4.9. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ, СУНГАХ ШИЙДВЭРИЙН ДАГУУ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА АЖЛЫН **5 ХОНОГ**Т БАГТААН ГҮЙЦЭТГЭНЭ.

5.3. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН ДАГУУ **БАРИЛГЫН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛЛАНА.**

5.4. ЭНЭ ЖУРМЫН 5.3-Д ЗААСАН **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ** БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 42.4-Т ЗААСАН “ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА, БҮРТГЭХ ЖУРАМ”-ЫН ДАГУУ **ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛСЭН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД БАЙНА.**


ЖУРАМД ТУССАН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД



6.7. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГЭЭСЭН, ҮРЭГДҮҮЛСЭН ШАЛТГААНААР НӨХӨН ОЛГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАСАН БОЛ** ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГЭЭСЭН ТУХАЙ ӨДӨР ТУТМЫН СОНИНД ЗАРЛУУЛЖ, СОНИНГИЙН ХАМТ НӨХӨН ОЛГОХ ХҮСЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛНЭ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА ХОЛБОГДОХ МАТЕРИАЛЫГ БҮРДҮҮЛЭН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛНЭ. АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТИЙГ ҮНДЭСЛЭН БАРИЛГЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ ШИЙДВЭРЭЭР ГЭРЧИЛГЭЭГ НӨХӨН ОЛГОНО.

6.15. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД БАРИЛГЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭ, **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА 1 ЖИЛЭЭС ДЭЭШ ХУГАЦААНД МЭДЭЭЛЛИЙН САНД ИРҮҮЛЭЭГҮЙ БОЛ** ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВХУУЛАХ САНАЛЫГ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛНЭ. ЭНЭ НЬ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.

“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” 2013 ОНЫ 89 ДҮГЭЭР ТУШААЛААР БАТЛАГДСАН СУУРЬ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ “ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР ТУШААЛТАЙ ДҮЙЦҮҮЛСЭН АРГАЧЛАЛ



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 02 сарын 23 өдөр Дугаар 33 Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ямны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 44.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга хот байгуулалтын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2018 оны 11 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих журам” батлагдаж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3841 дугаарт бүртгүүлсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагыг Барилга, хот байгуулалтын сайдын “Журам батлах тухай” 2013 оны 89 дүгээр тушаалаар батлагдсан ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагатай дүйцүүлсэн аргачлалыг нэгдүгээр хавсралтаар батлуулсугай.


2. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуй нэгжийн жагсаалтыг 2015, 2016, 2017, 2018 онуудаар дээрх аргачлалтай уялдуулан далгэрэнгүй гаргаж, нийтэд мэдээлэхийг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Соёмбоо/, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын ерөнхийлөгч /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.

3. Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон шинэчилсэн журам батлагдан гарахаас өмнө олгогдсон барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг тухайн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэй байхаар тооцсугай.

4. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хуульд заасны дагуу албан ёсоор мэдэгдэх, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

Х.БАДЕЛХАН

03 00136



Барилга, хот байгуулалтын сайдын
2018 оны 11 дүгээр сарын 19-өдрийн
33 дугаар тушаалын хавсралт

НЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

БХБ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага	БХБ-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага
Ажлын төрөл	**Ажлын төрөл**
1	2
1.1.1. Бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа	**3Т-9.1** Бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа
1.1.2. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа	**3Т-9.2** Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа
1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ)	**3Т-2.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ) **3Т-3.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ) **3Т-8.1** Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл
1.2.2. 1-16 давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, Барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ) Барилга байгууламжийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж (резервуар, бункер, силос, цамхаг, яндан, антенна гэх мэт)-ийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ)	**3Т-4.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ) **3Т-8.1** Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл
1.2.3. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ)	**3Т-4.10** Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ)
1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн	**3Т-6.1** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ



18 ДУГААР ЗҮЙЛ. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

18.1.Барилгын үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ.


18.2.Энэ хуулийн **10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах** барилга байгууламжийн барилгын ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхэлнэ.

18.3.Энэ хуулийн 10.1.1-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхэд энэ хуулийн 19.1.2-т заасан **тусгай зөвшөөрлийг шаардахгүй.**

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилгын салбарын хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг **төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.**



ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ 2017 ОНЫ 194 ДҮГЭЭР ТУШААЛ “БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛЛЫГ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛААР НЬ ТОГТООХ ДҮРЭМ”



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 12 сарын 25-ны өдрийн 3221 дугаарт бүртгэв.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 30 өдөр Дугаар 194 Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн батлагдсугай.

2. Дүрмийг холбогдох байгууллагуудад хүргүүлж мөрдүүлэх, биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Х.БАДЕЛХАН

03 00564



Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн 194 дугаар тушаалаар батлав.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛАЛЫГ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛААР НЬ ТОГТООХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилгын тухай хуулийн 10.1-д заасан барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг түүний зориулалт, төрөл, хүчин чадалтай уялдуулан тогтооход энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Барилга байгууламжийн зориулалт, төрөл, хүчин чадлыг Барилгын тухай хууль болон барилга байгууламжийн норматив баримт бичигт зааснаар тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг хэрэглэх хүрээ

2.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах, барилгын салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, барилгын ажилд захиалагчийн хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд зохицуулах үндэслэл болно.

Гурав. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал

3.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг тогтоохдоо доорх үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, овор хэмжээ;
- барилга байгууламжийн өндөр, урт, эзлэхүүн, талбай;
- барилгажилтын нягтрал;
- барилга байгууламжийн эрсдэлийн түвшин;
- галын аюулгүй байдлын зэрэглэл;
- эдийн засаг, нийгэм, экологийн үр дагаварт нөлөөлж болзошгүй техникийн шинж чанар.

3.2. Барилга байгууламжийн инженер хайгуулын судалгаа болон барилгын дотор инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын ангилалыг энэ дүрмийн 3.1-д заасан ангилалтай уялдуулан тодорхойлно.

3.3. Төвөгшлийн ангилалд хамруулах барилга байгууламжийн төрлийг энэ дүрмийн хавсралтаар тогтоосон болно.

1

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ 2017 ОНЫ 194 ДУГААР ТУШААЛ “БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛЛЫГ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛААР НЬ ТОГТООХ ДҮРЭМ”-ИЙН ХАВСРАЛТ

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрмийн хавсралт

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал тус бүрд хамаарах барилга байгууламжууд

№	Ангилал / төрөл	*1. Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж*	*2. Бага төвөгшилтэй барилга байгууламж*	*3. Дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж*	*4. Өндөр төвөгшилтэй барилга байгууламж*	*5. Онцгой төвөгшилтэй барилга байгууламж*
0	1	2	3	4	5	6
1	*Орон сууц*	**1.1.** 7 метр хүртэл өндөртэй 200м² хүртэл талбайтай нэг айлын орон сууц	**2.1.** 15 метр хүртэл өндөр нэг айлын орон сууц, олон айлын болон блокчилсон орон сууц	**3.1.** 15-31 метр хүртэл өндөртэй олон давхар орон сууцны барилга	**4.1.** 31-51 метр хүртэл өндөртэй олон давхар орон сууцны барилга	**5.1.** 51 метрээс дээш өндөртэй (16 давхраас дээш) орон сууцны өндөр барилгууд
2	*Төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга*		**2.2.** 15 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга байгууламжууд	**3.2.** 15-31 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж **3.3.** Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн байрны барилга	**4.2.** 31-51 метр хүртэл өндөртэй орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж **4.3.** Хүн олноор нэгэн зэрэг цуглах барилга (Энэ хавсралтын 2.7; 3.13 -д зааснаас бусад) **4.4.** Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлах **4.5.** Музей, үзэсгэлэнгийн барилга байгууламж **4.6.** Сүм, хийдийн барилга байгууламж **4.7.** Архивын барилга байгууламж	**5.2.** 51 метрээс дээш өндөртэй (16 давхраас дээш) орон сууцнаас бусад зориулалттай олон давхар барилга байгууламж **5.3.** Тусгай нөхцөл, техникийн даалгавар шаардагдах онцгой зориулалттай барилга байгууламж (засгийн газрын ордон, телевиз, эрчим хүчний станц, батлан хамгаалах болон хилийн цэргийн зориулалттай барилга байгууламжууд гэх мэт)
		-	**2.3.** 36 метрээс бага алгаслалтай барилга байгууламж	**3.4.** 37-60 метр хүртэл алгаслалтай барилга байгууламж	**4.8.** 61 метрээс дээш алгаслалтай барилга байгууламж	-

3

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ



19 ДҮГЭЭР ЗҮЙЛ. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

19.1.Дараахь барилгын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ:

19.1.1.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн **зураг төсөл боловсруулах;**

19.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн **барилгын ажил гүйцэтгэх;**

19.1.3.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх;

19.1.4.**даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх.**

19.2.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрх бүхий этгээд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн бүртгэлийг хөтөлж, мэдээллийг барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ



20 ДУГААР ЗҮЙЛ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

20.1.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын **10 өдрийн** дотор шийдвэрлэнэ.

20.2.Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг **зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.**

20.3.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд **Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна** дараахь баримт бичгийг энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан байгууллагад бүрдүүлж өгнө:

20.3.1.мэргэжилтнүүдийн талаархи мэдээлэл;

20.3.2.багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон тодорхойлолт, үйлдвэрлэлийн байрны талаархи мэдээлэл;

20.3.3.шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 20.3.2-т заасан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бусад хуулийн этгээдээс авч ашиглах тухай гэрээний хуулбар;

20.3.4.энэ хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн хувьд зураг төсөлд хийгдсэн магадлалын дүгнэлт.

.





ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

20.4.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохтой холбогдуулан энэ хуулийн **20.3-т зааснаас бусад баримт бичгийг шаардахыг хориглоно.**

20.5.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг **таван жилийн хугацаагаар** олгоно.

20.6.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 20.5-д заасан хугацаагаар сунгаж болно.

20.7.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан барилгын ажлын зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

20.8.Дараахь тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

20.8.1.энэ хуулийн 12, 13, 14, 15, 16 дугаар зүйлд тавьсан шаардлагыг зөрчсөн;


20.8.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг гурван жил дараалан эрхлээгүй.

20.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны мэдээ, тайланг энэ хуулийн 33.1.17-д заасан барилга байгууламжийн баримт бичгийн дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр хүргүүлнэ.

20.10.Энэ хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төслийг давтан хэрэглэхээр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахгүй



2018 ОНЫ БАЙДЛААР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРААС ӨГСӨН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ ЗОРИЛТ, ШААРДЛАГА

Мэдээллийн сан

Улсын хэмжээнд байдаг суурь мэдээллийн сангуудыг давхцуулж үүсгэдэг, мэдээллийн сангийн технологийг шинэчлэх шаардлагатай.

04

Шийдвэрлэх явц

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх явц тодорхойгүй байдгаас ААН байгууллагуудад хүндрэл үүсгэдэг.

03

02

Бичиг баримт бүрдүүлэлт

Олон төрлийн бичиг баримт бүрдүүлэх, нотариатаар батлуулах гэх мэт.

01

Хяналт

ААН байгууллагаас ирүүлсэн ИТА-ийн мэдээлэл болон бусад мэдээллийн хяналтыг хийх үйл ажиллагаа удаашралтай явагддаг.



АЧ ХОЛБОГДОЛ, ДАВУУ ТАЛ



Автоматжуулалт

Тусгай зөвшөөрлийг цахимаар хүссэнээс хойш бүх үе шатыг автоматаар хийх буюу тусгай зөвшөөрөл олгох хурал хүртэл процессийг автоматжуулсан.

Төлбөр төлөлт

Системийн тусламжтайгаар тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж гэх мэт төлбөрийг хийх болон төлбөр төлөлтийг шалгах боломжтой.

Бичиг баримт магадлах

Инженер техникийн ажилтны диплом, тухайн аж ахуйн нэгжид харьяалалтай эсэх мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийн сан руу төрийн мэдээлэл солилцооны системээр дамжин хандаж автоматаар шалгана.



Иргэн, ААН-ийн бүртгэл

Иргэн болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн давхцал арилж, мэдээллийн нэгдсэн сан бүрдэнэ.

Тусгай зөвшөөрлийн хяналт

Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн идэвхитэй хугацаанд тавих хяналт сайжирна.

ЦАХИМ СИСТЕМИЙН ҮНДСЭН ПРОЦЕСС



ААНБ бүртгүүлэх → **Мэдээлэл шалгах** → **Тусгай зөвшөөрөл хүсэх** → **Тусгай зөвшөөрөл олгох**

ААН бүртгүүлэх

ААНБ-ийн ерөнхий мэдээлэл, ИТА-ын мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг цахим системд бүртгүүлнэ.

Мэдээлэл шалгах

ААНБ-ийн мэдээллүүдийн үнэн зөв байдлыг төрийн мэдээлэл солилцооны системийн тусламжтайгаар автоматаар шалгана.

Тусгай зөвшөөрөл хүсэх

Тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагыг хангасан ААНБайгууллага хүсэлтээ илгээнэ.

Тусгай зөвшөөрөл олгох

Цахимаар ирүүлсэн шаардлага хангасан хүсэлтийг “Тусгай зөвшөөрлийн урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэг”-ийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

ЗОРИЛТ, ҮР ДҮН





Төрийн үйлчилгээ

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.

Ил тод байдал

Төр, иргэн, аж ахуй нэгжүүдийн харилцан итгэлцлийг бэхжүүлж, нээлттэй ил тод байдал сайжирна.

Тайлан, мэдээ

Салбарын бодлого боловсруулахад шаардлагатай суурь мэдээлэл, тайлан, мэдээ гаргахад хялбар болно.

Хяналт

Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд журамд заасан шалгуурыг ханган ажиллаж байгаа эсэхэд хялбар болно.

Нэгдсэн бүртгэл

Барилгын салбарын инженер, техникийн ажилтнууд, аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн бүртгэлтэй болно.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠭᠠᠭ ᠶᠡᠬᠡ ᠪᠠᠢᠭᠤᠤᠯᠯᠠᠯᠲᠤᠨ ᠶᠠᠮ



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
2018 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ